

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ҮР ДҮНД
СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨМА-2024/42-ШТА-ГА

Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр дүнтэй байна.

Даланзадгад хот 2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Аудитор М.Номиндарь

Утас: 70533552 Цахим хаяг: Nomindarim@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishiqbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Гарчиг

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	2
АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ	3
 БҮЛЭГ-1 ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА.....	5
А.1. Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар шаардлагатай мэдээ, мэдээлэл түгээсэн байна	5
А.2. Эрүүл мэндийн даатгалд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна	5
А.3. Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлэх орчин бүрдсэн байна	6
А.4. Эрүүл мэндийн байгууллагууд өөрийн тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж байна	7
А.5. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн нэхэмжлэлийн хяналтаар сумын эрүүл мэндийн төвүүдийн хасагдал өссөн байна.....	8
А.6. Сумын эрүүл мэндийн төвүүд 25.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.....	9
А.7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай байна	10
 БҮЛЭГ 2. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА	11
Б.1. Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хангалт нэмэгдсэн байна	11
Б.2. Ерөнхий боловсролын сургуулийн индекс, хөгжлийн дундаж түвшин буурсан байна	13
Б.3. Цэцэрлэг, сургуулийн багшийн хөгжилд 229.1 сая төгрөгийг зарцуулсан байна	14
Б.4. Сургууль, цэцэрлэгийн санхүүжилтийн төлөвлөгөөг үндэслэлтэй батлуулсан байна	14
Б.5. Сургууль, цэцэрлэгүүд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна	15
Б.6. Боловсролын салбарын хүний нөөцийн дутагдлыг нөхөх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн байна	17
 БҮЛЭГ 3 АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНГҮЙ БАЙНА	19
В.1. Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарт хяналтын тогтолцоо бүрдсэн байна	19
В.2. Хяналт-шинжилгээ үнэлгээг тогтмол хийж байна	21
В.3. Баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу дотоод аудитыг гүйцэтгэсэн байна	21
 ДҮГНЭЛТ	22
ЗӨВЛӨМЖ	23
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	24
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	25



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
График 1	Эрүүл мэндийн даатгалын хамралтын 2023 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	5
График 2	Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнгийн үзүүлэлт	13
График 3	Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнгийн үзүүлэлт:	17
Хүснэгт 1	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 он, 2024 оны байгууламж байгууламж, засварын ажил	6
Хүснэгт 2	Сумын ЭМТ-д бүртгэлтэй 2023 оны жилийн эцсийн байдлаарх эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж	7
Хүснэгт 3	Авлага, өглөгийн 2023 оны жилийн эцсийн байдлаарх үлдэгдэл	9
Хүснэгт 4	Олгогдсон урамшуулал, зарцуулалт 2022 он	20
Хүснэгт 5	Олгогдсон урамшуулал, зарцуулалт 2023 он	21
Хүснэгт 6	Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн үнэлгээ	24
Дүрслэл 1	Өрх, сумын ЭМТ-ийн эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг үнэлгээ	7
Дүрслэл 2	Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн нэхэмжлэлийн хяналт	8
Зураг 1	Ерөнхий боловсролын сургуулийн хүчин чадлыг харуулбал:	19



Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” тушаалыг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго

“Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны хэрэгжилт, үр дүнд” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаран холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Эрүүл мэндийн салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх,
- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх
- Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын хяналт, дотоод аудитын үйл ажиллагаа үр дүнтэй эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар, зарим сумдын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сум, багийн эрүүл мэндийн төвийн 2023 оны үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын арга зүй

Аудитын гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухай асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэсэн.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль (2022 он)
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996 он)
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005 он)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2015 он)



- Шилэн дансны тухай хууль (2014 он)
- Эрүүл мэндийн тухай хууль (2011 он)
- Боловсролын Ерөнхий хууль (2023 он)
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль (2023 он)
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015 он)
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль (2016 он)
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2023 оны тушаалууд
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны тушаалууд
- Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын 2022 оны А430, А/500 дугаар тушаал
- Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд;

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Т.Хишигбат, М.Номиндарь нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.

Ерөнхий мэдээлэл:

Аймгийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчийн 31 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Цэцэрлэгийн 185 бүлэгт үндсэн сургалтад 6617 хүүхэд, хувилбарт сургалтад 218 хүүхэд хамрагдаж байна. Цэцэрлэгийн нийт ажиллагсад 723, эрхлэгч 29, арга зүйч 20, үндсэн багш 213, туслах багш 180, бусад ажилтан 325 ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчийн 22 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж байна. Нийт 16385 суралцагчаас өдрөөр суралцагч 16366, дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч 19 байна. Сургуулийн нийт ажиллагсад 1337 байгаагаас захирал 22, сургалтын менежер 48, нийгмийн ажилтан 27, үндсэн багш 778, бусад ажилтан 462 байна.

Боловсролын тухай хуулийн 40.1 дэх заалтыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр өөрчлөн найруулснаар Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлүүлж, үр дүнгийн нэмэлт урамшуулал авах эрх зүйн орчин бүрджээ.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг 2022, 2023 онуудад зохион байгуулсан байна. Өмнөговь аймагт 2023 онд Ерөнхий боловсролын 22 сургууль, 1387 багш, 13528 сурагч, Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын үнэлгээнд 31 цэцэрлэг, 184 багш, 4468 хүүхэд хамрагдсан байна.

БҮЛЭГ-1 ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА.

А.1. Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар шаардлагатай мэдээ, мэдээлэл түгээсэн байна.

1.1. Аймгийн Эрүүл мэндийн газраас 2023 онд иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 95%-ийн биелэлттэй, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.



1.2. Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, мэдээлэл сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг 49 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 37,174 иргэн хамрагдсан байна.

1.3. Эрүүл мэндийн салбарын 18 байгууллага ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт нөлөөллийн 73 арга хэмжээг зохион байгуулж 6,450 иргэнийг хамруулсан бол бусад салбарын хамтын ажиллагааны хүрээнд 82 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байна.

1.4. Өмнөговь Эрүүл мэндийн газар нэртэй фейсбүүк хаягаар дамжуулан 2,130 төрлийн мэдээлэл, нийтлэлийг хүргэж давхардсан тоогоор 150,158 хүний хандалт авсан байна.

1.5. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2023 онд Эрүүл мэндийн даатгалын талаар аймгийн Орон нутгийн телевизэд 4 удаа ярилцлага, мэдээлэл өгсөн бол Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс фейсбүүкийн цахим хуудсаар 210 мэдээлэл нийтэлж 1,700 хүн үзэж танилцсан байна.


1.6. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд мөн адил өөрийн байгууллагын нэр дээрх фейсбүүк хаягаараа дамжуулан иргэд олон нийтэд мэдээлэл хүргэдэг байна.

Үүнээс дүгнэхэд иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар шаардлагатай мэдээ, мэдээллийг түгээж ажилласан байна.

А.2. Эрүүл мэндийн даатгалд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна.

2.1. Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2023 оны А/16 тушаалаар Малчид, оюутан суралцагчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд, гадаадын иргэн, харьяалалгүй иргэдийн эрүүл мэндийн даатгалын төлөвлөгөөг баталсан байна.

График-1: Эрүүл мэндийн даатгалын хамралтын 2023 оны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн тайлан

2.2. Эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөний биелэлт 2023 онд Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд 63%, оюутан суралцагчид 12%, малчид 73% байна.

2.3. Иргэд эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоолд заасны дагуу эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамаарч авдаг учир эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байх шалтгаан болж байна.




2.6. Иймээс эрүүл мэндийн даатгалд хамралтын талаарх судалгаа гаргаж, шалтгаан нөхцөл байдлыг тодорхойлсны үндсэн дээр тэдгээрт чиглэсэн арга хэмжээг авах шаардлагатай байна.

А.3. Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлэх орчин бүрдсэн байна.

3.1. Улсын төсвийн хөрөнгөөр Манлай, Номгон, Сэврэй сумын төвд 15 ортой, эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр ашиглалтад оруулах 6,160.6 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг баталж 2023 онд 3,308.4 сая төгрөг, Даланзадгад суманд 40 ортой, сэргээн засах эмнэлгийн барилга шинээр барих 4,692.0 сая төгрөгийн төсөв баталж 2023 онд 600.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.


График 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ /сая төгрөг/



Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль

3.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн салбарт 12,890.0 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээг баталж 2023 онд 11,942.7 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Дүрслэл 1. ОНТХО-аар 2023 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний ангилал




3.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 32 төсөл арга хэмжээг баталж 2023 онд 15,851.1 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэж эрүүл мэндийн байгууллагын орчин нөхцөлийг сайжруулахад анхаарч ажилласан байна.

3.3. Өрх, сумын ЭМТ-н эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг Монгол Улсын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны MNS 5081:2013, 2017 оны MNS 5292:2017 стандартаар тогтоож өгсөн байна.



Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны хэрэгжилт, үр дүн

Дүрслэл 1. Өрх, сумын ЭМТ-ийн эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг үнэлгээ



Өрхийн ЭМТ-ийн дундаж үнэлгээ

Сумын ЭМТ-ийн дундаж үнэлгээ

3.4. Эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтын дундаж үнэлгээ өрхийн ЭМТ-үүд 2023 онд 85 хувь болж 2.9 хувиар, сумын ЭМТ-үүд 91.2 хувь болж 5.3 хувиар өссөн байна.

Үүнээс дүгнэхэд өрх, сумын ЭМТ-н эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтын стандартыг мөрдөж ажилласан байна.

А.4. Эрүүл мэндийн байгууллагууд өөрийн тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж байна.

4.1. Өрхийн эрүүл мэндийн төвүүд 2023 оны жилийн эцсийн байдлаар 209 ширхэг, 623.0 сая төгрөгийн эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

	Өнө-Орших ӨЭМТ	Шимбилэг ӨЭМТ	Энхийн хүслэн ӨЭМТ
	250.5 сая төгрөгийн 55 ширхэг тоног төхөөрөмж	159.6 сая төгрөгийн 90 ширхэг тоног төхөөрөмж	212.9 сая төгрөгийн 64 ширхэг тоног төхөөрөмж

4.2. Сумын эрүүл мэндийн төвүүд 2023 оны жилийн эцсийн байдлаар 1869 ширхэг, 7,006.5 сая төгрөгийн эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байна.

Хүснэгт 2. Сумын ЭМТ-д бүртгэлтэй 2023 оны жилийн эцсийн байдлаарх эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж

№	Байгууллагын нэр	Тоног төхөөрөмжийн тоо ширхэг	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Баяндалай сумын ЭМТ	71	195.1
2	Баян-Овоо сумын ЭМТ	92	254.3
3	Булган сумын ЭМТ	49	146.1
4	Гурвантэс сумын ЭМТ	274	1,212.9
5	Манлай сумын ЭМТ	70	254.7
6	Мандал-Овоо сумын ЭМТ	110	189.3
7	Ноён сумын ЭМТ	85	346.4



8	Номгон сумын ЭМТ	172	437.8
9	Сэврэй сумын ЭМТ	180	351.1
10	Ханбогд сумын ЭМТ	150	1,453.0
11	Ханхонгор сумын ЭМТ	57	155.9
12	Хүрмэн сумын ЭМТ	42	86.1
13	Цогт-Овоо сумын ЭМТ	183	311.0
14	Цогтцэций сумын ЭМТ	334	1,612.8
НИЙТ ДҮН		1,869	7,006.5

Эх сурвалж: Аймгийн Эрүүл мэндийн газрын судалгаа

4.3. Өрх, сумын ЭМТ-д бүртгэлтэй эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж байна.


А.5. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн нэхэмжлэлийн хяналтаар сумын эрүүл мэндийн төвүүдийн хасагдал өссөн байна.

5.1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 сарын 29-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, хяналт тавих журмыг шинэчлэн баталсан байна.

5.2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 сарын 29-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, нэгж тохиолдлын тооцох, санхүүжүүлэх журам, эмийн зардлыг санхүүжүүлэх журам, өвчин эмгэг, түүний эмийн жагсаалт, хэлбэр, тун зэргийг шинэчлэн баталсан байна.

5.3. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн нэхэмжлэлийн хяналтаар 2023 онд өрхийн эрүүл мэндийн төвүүд 201 даатгуулагчийн 8,358,400 төгрөг хасагдаж өмнөх оноос 1,983,800 төгрөгөөр, сумын эрүүл мэндийн төвүүд 2,322 даатгуулагчийн 404,418,200 төгрөг хасагдсан нь өмнөх оноос 306,950,629 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2: Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн нэхэмжлэлийн хяналт /сая төгрөг/



Эх сурвалж: Аймгийн ЭМД-н хэлтсийн нэхэмжлэлийн хяналтын тайлан

5.4. Гүйцэтгэлийн санхүүжилтийн хасагдлын дүн өссөн нь эмнэл зүйн шалгуур хангаагүй, анхан шатны баримт ирүүлээгүй, оношийн код ахиулах бусад зөрчилтэй нэхэмжлэл ирүүлдэгтэй холбоотой байна.

5.5. Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 онд “Эрүүл мэндийн даатгал үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар сумын эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нэхэмжлэлийг



илгээх ажлыг сайжруулах албан шаардлагыг Эрүүл мэндийн газарт хүргүүлж Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран сургалт, зөвлөмж, цахим хурлыг зэргийг тогтмол хийсэн тухай хэрэгжилтийг ирүүлсэн боловч үр дүнгүй байна.

5.6. Иймд судалгаа гаргаж, шалтгаан нөхцөл байдлыг тодорхойлсны үндсэн дээр тэдгээрт чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлээ.

А.6. Сумын эрүүл мэндийн төвүүд 25.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

6.1. Сумын эрүүл мэндийн төвүүд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 14,733.5 сая төгрөгийн төсөв баталснаас 11,645.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 240.2 сая төгрөгийн авлагатай, 11.9 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна.

Хүснэгт-3: Авлага, өглөгийн 2023 оны жилийн эцсийн байдлаарх үлдэгдэл /сая төгрөг/

№	Байгууллагын нэрс	Авлага	Өглөг
1	Баяндалай сумын эрүүл мэндийн төв	18.6	
2	Баян-Овоо сумын эрүүл мэндийн төв	42.1	
3	Булган сумын эрүүл мэндийн төв	5.6	
4	Гурвантэс сумын эрүүл мэндийн төв	13.1	
5	Манлай сумын эрүүл мэндийн төв	9.7	
6	Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төв	13.7	
7	Ноён сумын эрүүл мэндийн төв	8.7	11.9
8	Номгон сумын эрүүл мэндийн төв	7.2	
9	Сэврэй сумын эрүүл мэндийн төв	11.2	
10	Ханбогд сумын эрүүл мэндийн төв	40.2	
11	Ханхонгор сумын эрүүл мэндийн төв	7.3	
12	Хүрмэн сумын эрүүл мэндийн төв	11.0	
13	Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төв	7.6	
14	Цогтцэций сумын эрүүл мэндийн төв	44.1	
НИЙТ ДҮН		240.2	11.9

6.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт дутуу олгосон учир 2023 онд 240.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна.

6.3. Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу өрх, сумын эрүүл мэндийн төвийн 2023.12.31-ны өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг хийсэн байна.

6.4. Сумын Эрүүл мэндийн төвд 10 өөрчлөлтгүй, 2 хязгаарлалттай дүгнэлт өгч, 2 түүвэрт хамруулсан байна.

6.5. Аудитаар 12,201.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 6,279.9 сая төгрөгийн алдааг залруулсан. Залруулагдаагүй 5.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 2,378.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3,536.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснээс 25.2 сая төгрөгийн зориулалт бусаар зарцуулсан зөрчил байна.

Цаашид Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.



А.7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

7.1. Эрүүл мэндийн ажилтны ачаалалтай уялдсан цалин хөлсний тогтолцоо бий болгох зорилгоор ажлын байрны үнэлгээнд суурилсан цалин хөлсний тогтолцоог улсын хэмжээнд нэвтрүүлэн, Засгийн газрын 2023 оны 06 сарын 21-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосон байна. Тус тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ыг тогтоосон байна.

7.2. Засгийн газрын 2024 оны 03 сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Тус тогтоолын зургаадугаар хавсралтаа “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг тогтоосон байна.

7.3. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээрийн зүйлийн 29.5¹-д заасны дагуу өрх, сумын эрүүл мэндийн төвд тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухай байгууллагаас олгож байна.

7.4. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 2023 онд 465 хүний орон тоог баталж гүйцэтгэлээр 408 хүн ажилласан байна.

7.5. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2023 онд 5 хүний орон тоо баталж гүйцэтгэлээр 2 хүн ажиллаж байна.

7.6. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 2023 онд 43 хүн ажил хавсран гүйцэтгэсэн бол 2024 оны 06 сарын байдлаар 32 хүн ажил хавсран гүйцэтгэж байна.

7.7. Энэ нь аймгийн эрүүл мэндийн салбар хүний нөөцийн дутагдалтай байгааг харуулж байна.

7.8. Сумын эрүүл мэндийн төвүүд хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг хангах зорилгоор эмнэлгийн ажилчдын байранд үнэ төлбөргүй амьдруулах, сумын төрийн албан хаагчдын түрээсийн орон сууцанд хамруулах, мөнгөн тэтгэмж олгох боломжийг бүрдүүлсэн боловч хүний нөөц бүрдээгүй байна.

7.9. Аймгийн Засаг даргын “Эзэмшсэн мэргэжлээрээ – Эх нутагтаа ажиллая” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хэрэгцээт боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор оюутан суралцагчдыг тэтгэлэгт хамруулж байна.

7.10. Тус хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 70 хүүхэд төгссөнөөс эрүүл мэндийн салбарын чиглэлээр 14, 2023 онд 13 хүүхэд төгссөнөөс эрүүл мэндийн салбарын чиглэлээр 3 оюутан

¹ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно.



төгсөн салбартаа ажиллаж байгаа боловч хүний нөөцийн дутагдлыг нөхөх хэмжээний үр дүнг бий болгоогүй байна.

7.8. Үүнээс дүгнэхэд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1², 13.1.3³-т заасны дагуу эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай, түргэн шуурхай авах боломжийг хязгаарлаж байна.

БҮЛЭГ 2. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА.

Б.1. Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хангалт нэмэгдсэн байна.

1.1. Боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэвийн нөхцөлийг хангах зорилгоор Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны а/230 дугаар тушаалаар сургалтын байгууллагад олгох тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал, санхүүжүүлэх хуваарилалт батлагдсан байна.

1.2. Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын 22 сургуульд олгох тоног төхөөрөмжийн 846,0 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсролын 31 цэцэрлэгт олгох тоглоом наадгай, зөөлөн эдлэл, тоног төхөөрөмжийн 112,5 сая төгрөг, нийт 958,5 сая төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтийг баталжээ.

1.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр сургууль, цэцэрлэг, дотуур байрыг засварлах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, хүүхдийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 15,597.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дараах ажлууд хийгдсэн байна.

Үүнд:

- 2023 онд 2 сургуулийн урлаг спортын заал барих,
- 8 сургууль, цэцэрлэгийн барилгын засварын ажил,
- 4 сургуулийн гадна талбайн тохижилтын ажил,
- 2 сургууль кабинет байгуулах,
- 12 сургууль цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах,
- 1 сургууль автобус нийлүүлэх.
- 22 сургуульд цахим кабинет байгуулах.

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлэх зорилтын хүрээнд 22 сургуульд "Ухаалаг цахим анги" байгуулж, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас 1,7 тэрбум төгрөгийг зарцуулсан.

1.4. Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний 6 шалгуур үзүүлэлтээс сургалтын байгууллагын сэтгэл ханамж болон сургалтын орчин бүрдүүлэлтийн үнэлгээг 2022, 2023 онуудаар харьцуулбал:

Ерөнхий боловсролын сургууль:

- Сургалтын байгууллагын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. (Суралцагчдын сэтгэл ханамж: 2022 онд 79.7 хувь > 2023

² Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй

³ Даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай, түргэн шуурхай үзүүлэх, даатгуулагчийг холбогдох мэдээллээр хангах



- онд 79.1 хувь, Эцэг, эхийн сэтгэл ханамж 2022 онд 81.1 > 2023 онд 77.1 хувь)
- Сургуулийн сургалтын орчин бүрдүүлэлтийн дундаж үнэлгээ 12.1 хувиар буурсан байна. (2022 онд 77.5%, 2023 онд 65.4%)

Аудитын хүрээнд 8 сургуулийн 110 багшаас санал асуулга авахад “Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжиж үр дүнгийн санхүүжилт олгогдсоноор ажлын байрны орчин нөхцөл сайжирсан уу?” гэсэн асуулгад 67 багш сайжирсан гэсэн байгаа ч хөндлөнгийн үнэлгээгээр сургалтын орчин бүрдүүлэлтийн үнэлгээ буурсан байна.

1.5. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал авсан Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл ханамжийн судалгааны дундаж 1.5 хувиар буурсан, урамшуулал олгогдоогүй сургуулийн судалгааны дундаж 2.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллага:

- Сургалтын байгууллагын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ 3.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. (2022 онд 88.2%, 2023 онд 95.0%)
- Сургалтын орчин бүрдүүлэлт гүйцэтгэл, үр дүн 4.8 хувь буурсан үзүүлэлттэй байна. (2022 онд 90.4%, 2023 онд 85.6%)

Аудитын хүрээнд 10 цэцэрлэгийн 65 багшаас санал асуулга авахад “Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжиж үр дүнгийн санхүүжилт олгогдсоноор ажлын байрны орчин нөхцөл сайжирсан уу?” гэсэн асуулгад 47 багш сайжирсан гэсэн байгаа ч хөндлөнгийн үнэлгээгээр сургалтын орчин бүрдүүлэлтийн үнэлгээ буурсан байна.

1.6. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал авсан цэцэрлэгийн сэтгэл ханамжийн үнэлгээ 2.8 хувиар өссөн, Урамшуулал аваагүй цэцэрлэгийн сэтгэл ханамжийн үнэлгээ 3.2 хувиар буурсан байна.

Үүнээс харахад байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр олгогдсон санхүүжилт сургууль, цэцэрлэгт дэмжлэг үзүүлсэн байна.

1.7. Сургууль, цэцэрлэгүүдэд 2023 онд улс, орон нутгийн төсвөөс нийт 16,556.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн хэдий ч сургалтын байгууллагын орчин бүрдүүлэлтийн үнэлгээ өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

1.8. Сургууль, цэцэрлэгт олгогдож байгаа хөрөнгө оруулалтыг харахад хүүхдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн сургууль, цэцэрлэгийн ойр орчмын зам талбайн тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан орчны тохижилт, хийгдээгүй байгаа нь сургалтын орчин бүрдүүлэлтийн үнэлгээнд нөлөөлсөн байна.


1.9. Үүнээс дүгнэхэд Сургууль, цэцэрлэгийн сургалтын орчин бүрдүүлэлтийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

Б.2. Ерөнхий боловсролын сургуулийн индекс, хөгжлийн дундаж түвшин буурсан байна.

2.1. Өмнөговь аймгийн 2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтын дүгээр аймгийн хэмжээст оноо 2022 оноос 9.42 оноогоор ахиж 10 байранд орсон үзүүлэлттэй байгаа ч 2020 онтой харьцуулахад 45.1 оноогоор буурсан байна.



График 2: Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнгийн үзүүлэлт



Бүрэн дунд боловсролыг 2023 онд өдрөөр төгссөн суралцагчдаас 75-88 хувь нь элсэлтийн ерөнхий шалгалтад оролцож их, дээд сургууль, коллежид элсэн суралцжээ.

2.2. Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний 6 шалгуур үзүүлэлтээс сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, бүрдүүлэлтийн 2022, 2023 оны үнэлгээг харьцуулахад:

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үзүүлэлт 1.4%-6% ахисан.
- Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн гүйцэтгэл, үр дүн 4.1% ахисан байна.

2.3. Ерөнхий боловсролын нийт 22 сургуулийн 2022 хөгжлийн түвшин болон индексийн түвшинг 2023 онтой харьцуулж үзэхэд:

- Индексийн түвшин 1-3 шатаар ахисан 3 сургууль, байна. Эдгээр сургуулийн хөгжлийн түвшин 1-2 шат, гүйцэтгэлийн хувь 3.8-7.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Индексийн түвшин 1-3 шатаар буурсан нийт 6 сургууль байна. Эдгээр сургуулийн хөгжлийн түвшин 1 шат, гүйцэтгэлийн хувь 0.8-4.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Индексийн түвшинд өөрчлөлт гараагүй нийт 13 сургууль байна. Эдгээр сургуулиас гүйцэтгэлийн хувь 0.2-8.3 хувиар өссөн 11 сургууль, гүйцэтгэлийн хувь 1.1-4.0 хувиар буурсан 2 сургууль байна.
- Нийт 16 цэцэрлэгээс 2 цэцэрлэгийн хөгжлийн түвшин ахисан, 10 цэцэрлэгийн хөгжлийн түвшин буурсан, 4 цэцэрлэгийн хөгжлийн түвшинд өөрчлөлт ороогүй байна.

2.4. 2022 онд гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн санхүүжилт авсан нийт 9 сургуулиас 1 сургуулийн индексийн түвшин ахисан, 6 сургуулийн индексийн түвшин буурсан, 2 сургуулийн индексийн түвшинд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Үүнээс харахад үр дүнгийн үнэлгээгээр олгогдож буй урамшуулал сурагчдын боловсролын түвшинд нөлөөлөөгүй байна.

Б.3. Цэцэрлэг, сургуулийн багшийн хөгжилд 229.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.1. Засгийн газрын 2024 оны “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” 39 дүгээр тогтоолын хавсралтаар газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 39 дүгээр



тогтоолын 1 дүгээр хавсралтаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүн, 2 дугаар хавсралтаар ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг сурагчдад ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүнийг баталсан байна.

3.2. Тус тогтоолоор суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормат түүний бүрэлдэхүүнд багшийн хөгжилд Ерөнхий боловсролын сургууль нийт хувьсах зардлын 0.9 хүртэл хувь, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 0.6 хувийг зарцуулахаар тусгагдсан байгаа нь багш нарыг мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломжоор хангасан байна.

3.3. Ерөнхий боловсролын 22 сургуулийн багшийн хөгжлийн зардалд 2023 онд улсын төсвөөс нийт 182.3 сая төгрөгийг төлөвлөж 176.4 сая төгрөгийг зарцуулсан, Сургуулийн өмнөх боловсролын 31 цэцэрлэг 55.5 сая төгрөгийг төлөвлөж 52.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.4. БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалын дагуу тасралтгүй хөгжлийг дэмжих үндсэн сургалтад давхардсан тоогоор ерөнхий боловсролын сургуулийн 1070 багш, цэцэрлэгийн 359 багшийг, бусад үйл ажиллагаанд давхардсан тоогоор ерөнхий боловсролын сургуулийн 678 багш, цэцэрлэгийн 349 багшийг хамруулсан байна.

3.5. Өмнөговь аймгийн “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлж Эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан, Боловсролын Мэдээллийн Технологийн Төв, МУИС, Гүрэн академи болон Зөвлөх тэргүүлэх зэрэгтэй багш нартай хамтран 36 удаагийн мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан байна.

3.6. Ийнхүү ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 673 багш үнэлэгдсэнээс 1-р индексэд 21, 2-р индексэд 74, 3-р индексэд 63, 4-р индексэд 121, 5-р индексэд 394 багш үнэлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 23 багшаар нэмэгдсэн байна.

Харин Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 184 багш үнэлэгдсэнээс 1-р индексэд 13, 2-р индексэд 19, 3-р индексэд 17, 4-р индексэд 29, 5-р индексэд 106 багш үнэлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 13 багшаар бага үзүүлэлттэй байгаа нь цэцэрлэгийн багш нарт чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Б.4. Сургууль, цэцэрлэгийн санхүүжилтийн төлөвлөгөөг үндэслэлтэй батлуулсан байна.

4.1. Боловсролын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5-д ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд хүүхдийн тоо, хэрэглээний үнийн түвшнээс хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр, хувьсах зардал болон үр дүнгийн үнэлгээнд үндэслэн төсөв тооцох аргачлал, санхүүжүүлэх журмыг Засгийн газар батлахаар тусгасан байна.

4.2. Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсрол эзэмшүүлэх болон сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, аргачлал баталсан. *Тус тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны 39 дүгээр тогтоолоор хүчингүй болгож хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүрийн журмыг шинэчлэн баталжээ.*



4.3. Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайд 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагаа, багшийн хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг, төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх зааврыг баталжээ.

4.4. Өмнөговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт ерөнхий боловсролын 22 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 33 цэцэрлэг 2023 оны санхүүжилтийн төлөвлөгөөг Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 91 дүгээр тогтоол, Боловсролын сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалын дагуу төлөвлөж санхүүжүүлсэн байна.

4.5. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын 22 сургууль нийт **40,526.3 сая** төгрөгийн төсөв батлуулсан байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сургуулийн өмнөх боловсролын 31 цэцэрлэг нийт **21,995.1 сая** төгрөгийн төсөв батлуулсан байна.

Б.5. Сургууль, цэцэрлэгүүд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

5.1. Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын 2022 оны А/500 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг зарцуулахад баримтлах чиглэл”-ийн 4.2-т Энэ аргачлалын 4.1-д заасан үйл ажиллагааг багш нарын зөвлөлийн хурлаар, багш, албан хаагчдад урамшуулал олгох хувь хэмжээг байгууллагын удирдах зөвлөлөөр тус тус хэлэлцэж батална. (Удирдлагад 30%, багш нарт 30%, бусад албан хаагчид 40%) гэж заасан байна.

5.2. Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын 2022 оны А/500 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг зарцуулахад баримтлах чиглэл”-ийн дагуу 2022, 2023 онуудад байгууллагын гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлсэн байна.

5.3. Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны А/343 дугаар тушаалаар гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн урамшуулалд Өмнөговь аймгийн 9 сургуульд нийт 175,2 сая төгрөг, 16 цэцэрлэгт нийт 261,7 сая төгрөгийг, 2023 онд 7 сургуульд нийт 137,7 сая төгрөг, 9 цэцэрлэгт нийт 115,1 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Хүснэгт 4. Олгогдсон урамшуулал, зарцуулалт 2022 он

№	Байгууллага	Нийт олгогдсон мөнгөн дүн	Үйл ажиллагааг сайжруулахад зарцуулсан мөнгөн дүн	/сая төгрөг/ Албан хаагчдыг урамшуулалд зарцуулсан дүн
1	Даланзадгад сумын 3-р сургууль	49.8	17.4	32.3
2	Баяндалай сумын сургууль	13.6	4.7	8.1
3	Баян-Овоо сумын сургууль	12.7	4.4	8.2
4	Булган сумын сургууль	13.8	4.8	9.0
5	Манлай сумын сургууль	19.4	6.2	12.6
6	Номгон сумын сургууль	19.2	5.1	12.5
7	Ноён сумын сургууль	24.1	8.4	15.7
8	Ханхонгор сумын сургууль	10.3	3.6	6.7
9	Хүрмэн сумын сургууль	11.9	4.1	7.7



Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны хэрэгжилт, үр дүн

10	Даланзадгад. 1-р цэцэрлэг	37.0	12.9	24.0
11	Даланзадгад. 2-р цэцэрлэг	13.5	4.7	8.8
12	Даланзадгад. 4-р цэцэрлэг	29.3	10.2	19.0
13	Даланзадгад. 8-р цэцэрлэг	21.5	7.5	13.9
14	Даланзадгад. 9-р цэцэрлэг	13.1	4.6	8.5
15	Даланзадгад. 24-р цэцэрлэг	7.5	2.6	4.9
16	Даланзадгад. 25-р цэцэрлэг	24.8	8.6	16.1
17	Гурвантэс. 3-р цэцэрлэг	30.9	10.8	20.1
18	Гурвантэс. 28-р цэцэрлэг	12.7	4.4	8.2
19	Номгон. 14-р цэцэрлэг	7.8	2.7	5.1
20	Ноён. 16-р цэцэрлэг	8.0	2.8	5.2
21	Ханбогд. 21-р цэцэрлэг	14.9	5.2	9.7
22	Хүрмэн. 18-р цэцэрлэг	3.1	1.1	2.0
23	Цогтцэций. 6-р цэцэрлэг	14.0	4.9	9.1
24	Цогтцэций. 7-р цэцэрлэг	9.0	3.1	5.8
25	Цогтцэций. 27-р цэцэрлэг	13.8	4.8	9.0

Эх сурвалж: Сургууль. цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаас

Хүснэгт 5. Олгогдсон урамшуулал. зарцуулалт 2023 он

/сая төгрөг/

№	Байгууллага	Нийт олгогдсон мөнгөн дүн	Үйл ажиллагааг сайжруулахад зарцуулсан мөнгөн дүн	Албан хаагчдыг урамшуулалд зарцуулсан мөнгөн дүн
1	Даланзадгад сумын 1-р сургууль	76.3	26.6	49.6
2	Баяндалай сумын сургууль	12.0	4.2	7.8
3	Баян-Овоо сумын сургууль	15.1	5.2	9.8
4	Номгон сумын сургууль	8.7	3.0	5.6
5	Ноён сумын сургууль	3.9	1.3	2.5
6	Сэврэй сумын сургууль	14.7	5.1	9.5
7	Хүрмэн сумын сургууль	6.7	2.3	4.3
8	Даланзадгад. 2-р цэцэрлэг	13.6	4.7	8.8
9	Даланзадгад. 24-р цэцэрлэг	7.5	2.6	4.9
10	Даланзадгад. 25-р цэцэрлэг	8.5	7.2	5.5
11	Даланзадгад. 26-р цэцэрлэг	26.4	9.2	17.2
12	Баяндалай. 13-р цэцэрлэг	2.8	1.0	1.8
13	Гурвантэс. 3-р цэцэрлэг	7.3	2.5	4.7
14	Ханбогд 29-р цэцэрлэг	17.1	5.9	11.1
15	Цогт-Овоо 12-р цэцэрлэг	13.4	4.7	8.7
16	Цогтцэций. 7-р цэцэрлэг	18.2	6.3	11.8

Эх сурвалж: Сургууль. цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаас

5.4. Үүнээс харахад сургалтын байгууллагад олгогдсон үр дүнгийн нэмэлт урамшууллыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Харин Даланзадгад сумын 25-р цэцэрлэг. Гурвантэс сумын 3 дүгээр цэцэрлэг. Цогтцэций сумын 7 дугаар цэцэрлэг. 27 дугаар цэцэрлэгүүд байгууллагын үйл ажиллагааны чанар. үр дүнгийн 2022. 2023 оны үнэлгээгээр олгосон санхүүжилтийг зарцуулахдаа нягтлан бодогчийг удирдлагад тооцож урамшуулал олгосон болон туслах багш нарыг багшид тооцон урамшуулал олгосон алдаа зөрчлүүд илэрсэн.

5.5. Цаашид Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл. чанар. үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”-ын 3.4-т заасан тогтоосон хувь хэмжээгээр холбогдох албан тушаалтнуудад урамшууллыг олгож байх албан шаардлагыг хүргүүллээ.



Б.6. Боловсролын салбарын хүний нөөцийн дутагдлыг нөхөх. тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн байна.

6.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5.4-т “Ерөнхий боловсролын сургуулийн долоо хоногт хичээллэх цагийн тоо. ээлжит хичээлийн үргэлжлэх болон суралцагчийн амралтын хугацааг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно” гэж заасан байдаг.

6.2. Боловсрол. соёл. шинжлэх ухааны сайд. Нийгмийн хамгаалал. хөдөлмөрийн сайд. Сангийн сайдын 2007 оны 08 дүгээр сарын 31-ны өдрийн хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэг. ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох. багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 11-т⁴ ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын нормд 19 цагийг хичээл заах цаг. 6 цагтай тэнцэх бусад ажлыг гүйцэтгэхээр тогтоосон байна.

6.3. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/350 дугаар тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөг баталсан. Сургалтын төлөвлөгөөний дагуу хичээлийн сургуулийн багшийн орон тоог тогтоосон байна.

№	БАЙГУУЛЛАГА	ТӨГСӨЛТ	БҮЛГИЙН ТОО			ҮНДСЭН БАГШИЙН ТОО		
			2021-2022	2022-2023	2023-2024	2021-2022	2022-2023	2023-2024
1	Даланзадгад сумын 1-р сургууль	12	58	62	67	82	88	86
2	Даланзадгад сумын 2-р сургууль	12	24	25	26	33	33	34
3	Даланзадгад сумын 3-р сургууль	12	44	45	45	60	60	62
4	Даланзадгад сумын 4-р сургууль	12	34	35	36	49	50	52
5	Даланзадгад сумын 5-р сургууль	12	52	54	59	67	75	79
6	Даланзадгад сумын 7-р сургууль	12	10	10	10	28	26	27
7	Баяндалай сумын сургууль	12	13	13	13	22	20	17
8	Баян-Овоо сумын сургууль	9	9	9	9	12	11	12
9	Булган сумын сургууль	9	11	11	11	17	17	18
10	Гурвантэс сумын сургууль	12	36	37	37	53	53	53
11	Мандал-Овоо сумын сургууль	9	9	9	9	13	13	13
12	Манлай сумын сургууль	9	17	17	17	21	22	22
13	Номгон сумын сургууль	9	12	13	12	16	16	16
14	Ноён сумын сургууль	9	9	9	9	13	12	11
15	Сэврэй сумын сургууль	9	10	10	10	16	14	13
16	Ханбогд сумын 1-р сургууль	12	25	29	32	37	42	49
17	Ханбогд сумын 2-р сургууль	12	31	33	35	41	42	49
18	Ханхонгор сумын сургууль	12	12	12	12	21	23	21
19	Хүрмэн сумын сургууль	9	9	9	9	11	12	13
20	Цогт-Овоо сумын сургууль	9	11	12	12	16	17	17
21	Цогтцэций сумын 1-р сургууль	12	35	37	39	48	51	56
22	Цогтцэций сумын 2-р сургууль	12	42	42	44	61	58	61
НИЙТ			513	533	553	737		

Сумдын сургуулийн хүүхдийн тоо анги дүүргэлтээс шалтгаалж хичээлийн төлөвлөгөөний дагуу сургалт явуулахад багшийн ажлын нормд заасан цаг хүрэлцэхгүй байгаагаас олон

⁴ “Сургуулийн багш долоо хоногт 34 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ажил, 6 цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэнэ. Стандартыг хэрэгжүүлэх ажилд ногдох 34 цагийн 19 цаг нь хичээл заах цагт зориулагдана”



төрлийн хичээлийг давхар заах нөхцөл байдал үүч байна. (Жишээ нь: Хими биологийн хичээлийг 1 багш заах)

6.4. 2023-2024 оны хичээлийн жилд 22 сургуулийн сул орон тоон дээр шинээр 130 багш авч ажиллуулсан байна.

6.5. Үүнээс: Өмнөговь аймгаас 67 иргэн. өөр аймаг. орон нутгаас шилжин ирж ажиллаж байгаа 63 иргэн буюу нийт сул орон тоог нөхсөн багш нарын 48.4% нь гаднаас ирж багшилж байгаа нь эзэлж байна.

6.6. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 2/4 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Нутгийн хишиг" хөтөлбөр-ийг батлан хэрэгжүүлж байгаа нь боловсролын салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлж байна.

“Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая” хөтөлбөрийн хүрээнд 2023 онд оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн 105 оюутан. Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн 48 оюутан. Глобал Удирдагч Их сургуульд суралцаж байгаа 105 төрийн албан хаагч. Засаг даргын дэмжлэгт 12 оюутан. нийт 270 суралцагчид 417.3 сая төгрөгийг оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн зардлаас зарцуулсан байна.

6.7. 2023-2024 оны хичээлийн жилд 6 салбарын 30 гаруй мэргэжлээр 60 оюутныг сонгон шалгаруулалтаар шинээр хамруулж гэрээ байгуулж тэтгэлэг хамруулжээ.

Аймаг орон нутгийн хөрөнгөөр тэтгэлэгт хамрагдсан оюутнуудаас боловсрол. нийгмийн салбарын чиглэлээр 2022 онд төгссөн 27 оюутнаас 2 оюутан гэрээний дагуу дутагдалтай орон тоонд зуучлан ажиллуулж байна.

6.8. Боловсрол соёл. шинжлэх ухаан. спортын сайд. Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад. захиргааны удирдлага. боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг баталсан байна⁵.


6.9. Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын 13 сургуулийн суралцагчийн тоо хүчин чадлаас давсан. 9 сургуулийн суралцагчийн тоо хүчин чадлаас бага байна. Зарим сумдын 320 хүүхдийн хүчин чадалтай сургуульд 110-369 хүүхэд суралцаж байна. Тус сургуулиуд батлагдсан цалингийн сандаа багтааж үйлчилгээний албан хаагчдыг авч ажиллуулж байна.

Үүнээс харахад суралцагчдын тоо бага сургуулиуд багшаас бусад. захиргааны удирдлага. боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативаар албан хаагчдыг ажиллуулахад цалингийн сан хүрэлцэхгүй байх эрсдэл үүсэхээр байна.

⁵ Заавар: 1 Сургуулийн сурагчийн тоог сургуулийн барилга байгууламжийн хүчин чадлаар тооцно.



Зураг 1: Ерөнхий боловсролын сургуулийн хүчин чадлыг харуулбал⁶:



БҮЛЭГ 3 АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНД. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХЯНАЛТ. ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНТЭЙ БАЙНА .

В.1. Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарт хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

1.1.Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн болон гүйцэтгэлийн үнэлгээний 2022, 2023 оны үр дүнгийн үзүүлэлтэд харьцуулсан үнэлгээ хийж дүгнэлт гарган зөвлөмж хүргүүлсэн байна.

1.2.Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээс ерөнхий боловсролын 22 сургуулийн 31.8% нь I-IV түвшинд үнэлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 8.4%-иар буурсан үзүүлэлттэй.

1.3. Байгууллагын үнэлгээг 15 сумдаар тодорхойлоход 9 сум өссөн, 6 сум буурсан, сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын байгууллагын нэгдсэн үнэлгээгээр 4 сум буурсан байгаа нь үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөх, сайжруулахад гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэх шаардлагатай байна гэж үзэж ерөнхий боловсролын сургуулийн сургалтын байгууллагын түвшинд 8, ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн түвшинд 4, сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын түвшинд 6, сургуулийн өмнөх боловсролын багшийн гүйцэтгэлийн түвшинд 11 нийт 29 зөвлөмж өгч ажилласан байна.

1.4. Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн үзүүлэлтэд дүгнэлт хийж зөвлөмж хүргүүлж байгаа нь сайшаалтай боловч үр дүнгийн үзүүлэлтээр санхүүжилт авсан байгууллагуудын зарцуулалтын тайланд хяналт тавьж ажиллаагүй байна.

1.5. Цаашид Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар.

⁶ Өмнөговь аймгийн боловсрол шинжлэх ухааны газар “Боловсролын салбарын статистик мэдээлэл” эмхэтгэл 2024 он



үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ын дагуу нэмэлт урамшууллыг зарцуулалтад хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

1.6. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын 22 сургууль. 31 цэцэрлэг байгууллагын даргын тушаалаар дотоод хяналтын багийг байгуулсан байна.

1.7. Дотоод хяналтын баг ажлын жилийн төлөвлөгөөгөө батлуулан улирал бүр ажлын удирдамж гарган дотоод хяналтыг хийж тайланг улирал тутам Боловсрол, шинжлэх ухааны газрын боловсролын хяналтын улсын байцаагчид хүргүүлэн ажиллаж байна.

1.8. Боловсрол, шинжлэх ухааны газраас байгууллагуудын ирүүлсэн тайлан, дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж өгч ажилласан байна.

1.9. Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Нутгийн хишиг" хөтөлбөрт Боловсролын салбарт хэрэгжүүлэх "Сурагч солилцоо" хөтөлбөр, "Чадварлаг багш" хөтөлбөр, "Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая", "Говийн ирээдүй- Хүүхэд", "Цахим Өмнөговь" нийт 6 төсөл, хөтөлбөр тусгагдсан байна.

1.10. Аймгийн засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан тус журмын 7.1-д "Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино" гэж заасны дагуу боловсролын салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан байна.

Хүснэгт 6. Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн үнэлгээ:

№	Хөтөлбөрийн нэр	1-р зорилт	2-р зорилт	3-р зорилт	4-р зорилт	5-р зорилт	6-р зорилт	Дундаж үнэлгээ
1	"Сурагч солилцоо"	85%	90%	77.5%	-	-	-	84.0%
2	"Цахим Өмнөговь"	81%	76%	54%	69%	-	-	70.0%
3	"Чадварлаг багш"	87%	89%	86.2%	-	-	-	87.4%
4	"Говийн ирээдүй- Хүүхэд"	89.2%	90%	87.5%	95%	-	-	90.4%
5	"Нутгийн дэм"	100%	100%	-	-	-	-	100.0%
6	"Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая"	78%	79%	85%	-	-	-	80.6%
7	"Нээлттэй Өмнөговь"	93.7%	-	-	-	-	-	80.0%
Дундаж үнэлгээ								84.6%

Эрүүл мэндийн салбар:

1.11. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор эрүүл мэндийн байгууллагаас гэрээний дагуу худалдан авах тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх "Чанар, төлбөрийн хяналтын журам"-ыг баталсан байна.

1.12. Тус журмын нэгдүгээр хавсралтаар "Нэхэмжлэлийн хяналтын шалгуур", хоёрдугаар хавсралтаар "Шалгуурын кодын тайлбар", гуравдугаар хавсралтаар "Нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдлын мэдээллийг эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх хуудасны загвар"-г баталсан байна.



1.13. Дээрх тогтоол, журмын дагуу аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлийг хянаж, шалгуур хангаагүй тусламж үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэлийн дүнгээс хасалт хийсэн байна.

В.2. Хяналт-шинжилгээ үнэлгээг тогтмол хийж, үр дүнг тооцож байна.

2.1. Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Нутгийн хишиг" хөтөлбөрт Боловсролын салбарт хэрэгжүүлэх "Сурагч солилцоо" хөтөлбөр, "Чадварлаг багш" хөтөлбөр, "Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая", "Говийн ирээдүй- Хүүхэд", "Цахим Өмнөговь" нийт 6 төсөл, хөтөлбөр тусгагдсан байна.

2.2. Аймгийн засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан тус журмын 7.1-д "Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино" гэж заасан байна.

Хүснэгт 6. Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн үнэлгээ

№	Хөтөлбөрийн нэр	1-р зорилт	2-р зорилт	3-р зорилт	4-р зорилт	5-р зорилт	6-р зорилт	Дундаж үнэлгээ
1	"Сурагч солилцоо"	85%	90%	77.5%	-	-	-	84.0%
2	"Цахим Өмнөговь"	81%	76%	54%	69%	-	-	70.0%
3	"Чадварлаг багш"	87%	89%	86.2%	-	-	-	87.4%
4	"Говийн ирээдүй- Хүүхэд"	89.2%	90%	87.5%	95%	-	-	90.4%
5	"Нутгийн дэм"	100%	100%	-	-	-	-	100.0%
6	"Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая"	78%	79%	85%	-	-	-	80.6%
7	"Нээлттэй Өмнөговь"	93.7%	-	-	-	-	-	80.0%
Дундаж үнэлгээ								84.6%

2.3. Боловсролын салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан байна.

Эрүүл мэндийн салбар:

2.3. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ны өдрийн А/346 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баталсан байна.

2.4. Тус журмын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Эрүүл мэндийн газрын 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 90.4 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн". Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 86.1%-тай "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлсэн байна.

2.5. Аймгийн Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн төлөвлөгөөний дагуу Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ыг удирдлага болгон Эрүүл мэндийн газрын 4 хэлтэс, 1 төвийн ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 96%-тай үнэлсэн байна.



2.5. Үүнээс дүгнэхэд эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, үр дүнг тооцдог байна.

В.3 Баталсан төлөвлөгөө удирдамжийн дагуу дотоод аудитыг гүйцэтгэсэн байна.

3.1. Аймгийн засаг даргын 2024 оны “Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх тухай” 02 дугаар удирдамжийн дагуу Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

1. “Нутгийн дэм хөтөлбөр”-ийн зарцуулалтаар эрүүл мэндийн салбарын 6 байгууллагад 5.7 сая төгрөгийн акт, 5.0 сая төгрөгийн албан шаардлага, боловсролын салбарын 28 байгууллагад 43.7 сая төгрөгийн акт, 8.3 сая төгрөгийн албан шаардлага,

2. “Хүүхдийн хоол, үдийн хоолны санхүүжилтийн хэрэгжилт”-д хяналт шалгалт 21 байгууллагад 65.4 сая төгрөгийн акт, 23.5 сая төгрөгийн албан шаардлагыг өгч ажилласан байна.

ДҮГНЭЛТ

- Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар шаардлагатай мэдээ, мэдээлэл түгээсэн байна.
- Эрүүл мэндийн даатгалд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна.
- Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлэх орчин бүрдсэн байна.
- Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн нэхэмжлэлийн хяналтаар сумын эрүүл мэндийн төвүүдийн хасагдал өссөн байна.
- Сумын эрүүл мэндийн төвүүд 25.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Боловсролын салбарын үр дүнд суурилсан тогтолцоо цэцэрлэг, сургуулиудын орчинд эерэг нөлөө үзүүлсэн байна.
- Боловсролын салбарын үр дүнд суурилсан тогтолцоо нь цэцэрлэг, сургуулийн суралцагчдын боловсролын түвшинд нөлөө үзүүлээгүй байна.
- Сургууль, цэцэрлэгт багшийн хөгжлийн зардалд төсөв баталж өгсөн нь багш нарын мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломжоор хангагдаж байна.
- Боловсролын салбарт хийгдэж буй үр дүнд суурилсан санхүүжилтийн төлөвлөгөөг үндэслэлтэй батлуулсан байна.
- Боловсролын байгууллагууд батлагдсан төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Боловсролын салбарын хүний нөөц тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн хэдий ч хүний нөөцийн дутагдлыг нөхөхөд хүндрэл бэрхшээл байсаар байна.
- Аймгийн боловсролын салбарын хяналт, дотоод аудитын үйл ажиллагаа үр дүнгүй байна

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн эрүүл мэндийн газарт:

- Өрх, сумын эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн дутагдлыг нөхөх. Чадавхжуулах, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах.



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/24

Даланзадгад сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус хүргүүлэхийг Ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах аудитор (Г.Шижирболд)-т даалгасугай.
4. Аудиттай холбоотой ажлын баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг Аудитор (Т.Хишигбат)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

016010965



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

3 дугаар баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083

Утас: (+976) 7053 3719, 7053 2307,

Цахим шуудан: umnogoviemg@gmail.com

Цахим хуудас: om.mohs.gov.mn

2024.06.27 № 556


танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлтэй танилцлаа.

Тус тайлан, асуудлын бүртгэлд манай байгууллагаас саналгүй болно.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

.. 462403311



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ГУРВАНТЭС СУМЫН 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ

Урт баг, Гурвантэс сум, Өмнөговь аймаг, 46155

Утас: (976) 7053 6450

Цахим шуудан: gurvantes.tsetserleg@gmail.com

2024.06.27 № 55
танай _____-ны № _____-т

Г ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН Г
АУДИТЫН ГАЗАР-т

САНАЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны хэрэгжилт, үр дүнд аудитаар илэрсэн алдаа зөрчлийн тайлантай танилцлаа. Байгууллагын үйл ажиллагааны нэмэлт урамшууллыг олгохдоо багшийн туслах нарыг үнэлгээний багш нар, бусад албан хаагчид гэсэн ангиллын аль ангилалд оруулах талаар тодорхой чиглэл өгч хамтран ажиллана уу.

ЭРХЛЭГЧ  Э.ТЭРБИШ

